


САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
БАЗАРЖАВ ОВОГТОЙ БАЙГАЛЬМААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин(биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
ЗОРИЛТ 1. САЛБАРЫН ХЯНАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО.							
1.	Арга хэмжээ 1.1. “Эмнэлгийн оношилгоо,эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах” 10.1.1,10.1.11,10.1.4 кодтой хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, батлуулна.	Батлагдсан хяналтын хуудасны тоо	ЭМС-ын 2023 оны А/78 дугаар тушаал	Эрүүл мэн дийн сайдын тушаалаар батлуулан байна.	Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах 10.1.1,10.1.11,10.1.4 кодтой 3 хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, холбогдох эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч нараас санал авч тусган Эрүүл мэндийн сайдын А/76 дугаар тушаалаар батлагдаж аймаг, нийслэлийн эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагчдад хүргүүлэн ажиллав.	2023.01.02-2024.02.05	100%
	Дэд арга хэмжээ 1.1.1: “Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах” 10.1.1,10.1.11,10.1.4 кодтой хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулах талаар холбогдох чиглэлийн улсын байцаагч нараас санал авч, хяналтын	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь			Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын 472 дугаар тогтоол, 2 стандарт, 10 Эрүүл мэндийн сайдын тушаал, заавар шинэчилж гарсантай холбоотой улс, хувийн хэвшлийн ортой эмнэлэг, тусгай мэргэжлийн оргүй төв, эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах (10.1.1,10.1.11,10.1.4) кодтой (3) хяналтын хуудсанд 20 асуулт, 260 оноо	2024.01.02-2024.02.05	

AM




	хуудасны шинэчилсэн төсөл боловсруулна.				нэмж нэмэлт өөрчлөлт оруулсан.		
	Дэд арга хэмжээ 1.1.2: “Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах” 10.1.1, 10.1.11, 10.1.4 кодтой Улсын байцаагч нарын дунд хяналтын хуудасны шинэчилсэн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, батлуулах арга хэмжээг зохион байгуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь			Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр улс, хувийн хэвшлийн ортой эмнэлэг, тусгай мэргэжлийн оргүй төв, эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг шалгах 3 хяналтын хуудсанд нэмэлт өөрчлөлт оруулж, холбогдох чиглэлийн мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж, 25 эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч нарын дунд хяналтын хуудасны шинэчилсэн төслийг хэлэлцүүлж, санал авч тусгасан. ЭМС-ын А/76 дугаар тушаалаар батлагдсан тул аймаг, нийслэлийн эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч нарт хүргүүлсэн.	2024.01.02-2024.02.15	
2.	Арга хэмжээ 1.2. Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр 2023 онд хийсэн хяналт шалгалтын дүнд үндэслэн холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлан нэгтгэж, боловсронгуй болгох санал боловсруулна.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	71%	72%	Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр хийсэн төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг үндэслэн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг боловсронгуй болгох саналыг хүргүүлсэн. Тухайлбал: - Эрүүл мэндийн тухай хуулийн 36.1 дэх “Эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрсөн аргаар оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулна.” гэсэн заалтыг хэрэгжүүлэх механизмыг тодорхой болгох; - Эрүүл мэндийн тухай хуулийн 42.2, 42.3 дахь заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах. - Зөрчлийн тухай хуулийн 6.8 дугаар зүйл. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль зөрчих гэсэн хэсгийн 1-д: Мэргэшсэн эмч, эсхүл резидент эмч хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, тодорхой мэргэжлийн	2024.01.02-2024.12.29	65.0%
		Хүргүүлсэн санал	5	Санал боловсруулсан байна.			

MA




					<p>үйл ажиллагаа явуулах эрхийг нэг бол хүртэл хугацаагаар хасаж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заалтад бага эмч, сувилагч гэж нэмж нэмэлт өөрчлөлт оруулах;</p> <p>-Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйл-/шийтгэлээс чөлөөлөх үндэслэл/- ийн 4-д заасан: "Төрийн албан хаагчийн хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуульд заасан зөрчлийн шинжтэй бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл хүлээлгэнэ. гэснийг төрийн албан хаагч гэснийг судалж өөрчлөх.</p> <p>- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/445 дугаар тушаалаар эмнэлзүй, анатомийн эмгэг судлаач эмчийн үндсэн мэргэжил нь хүний их эмч, төрөлжсөн мэргэшил нь эмнэлзүй, анатомийн эмгэг судлаач эмч байна гэж заасан байна. Иймд биоанагаах мэргэжилтэй эмнэлзүйн эмгэг судлаачаар мэргэшээд төгссөн хүний ажлын байрыг тодорхой болгож тушаалд өөрчлөлт оруулах.</p> <p>- Байгууллага аж ахуй нэгжид зөрчил арилгуулахаар өгсөн улсын байцаагчийн албан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ тодорхойгүй байгаа тул Зөрчлийн тухай хуульд нэмэлт заалт оруулж өгөх.</p> <p>-Эрүүл мэндийн байгууллагуудад хийгдсэн хяналт шалгалтын дүнгээс үзэхэд: Шалгалтанд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагуудын хэмжээнд эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилт-68 хувь байна.</p>		
ЗОРИЛТ 2. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.							
3.	Арга хэмжээ 2.1. Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн	Объектын хамралтын	89%	100%	Эмчилгээний чанарын хяналтаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 375 эрүүл мэндийн байгууллагыг төлөвлөгөөт хяналт	2024.02.01-2024.09.25	97.3%

2/2




<p>эмнэлгүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалттай ажлыг зохион байгуулна.</p>	<p>хувь</p>		<p>шалгалтанд хамруулахаар төлөсөнөөс 367 буюу 97.6 % нь төлөвлөгөөт хяналт шалгалтанд хамруулсан.</p> <p>Шалгалтад үйл ажиллагаа явуулаагүй 19 эрүүл мэндийн байгууллагыг авч үзвэл хаяг байршил дээрээ үйл ажиллагаа явуулаагүй-9 (нийслэл 6, Хөвсгөл 2, Ховд 1), эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан-2 (нийслэл), барилгын засварын ажил дуусаагүй-1 (нийслэл), захирал нь өвчтэй-1(Баян-Өлгий), үйл ажиллагаа зогссон-6 (Нийслэл 2, Хэнтий, Ховд), шалгалт хийгдээгүй-8 (Хөвсгөл, Ховд бензин шатахууны зардал томилолтын зардал байхгүй) шалтгаанаар хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлээгүй, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг олгосон байгууллагад тавьж шийдвэрлүүлсэн.</p> <p>Дээрх эмнэлгүүдэд 10 хяналтын хуудсаар үнэлэхэд эрсдэлийн түвшин 27 эмнэлэг буюу 8% нь их, 185 буюу 53 % нь дунд, 136 буюу 39 % нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн.</p> <p>Илэрсэн зөрчлийг үндэслэн улсын байцаагчид 230 эмнэлэгт 1927 заалт бүхий хугацаатай албан шаардлагаар үүрэг даалгавар өгч ажилласан.</p> <p>-Зэвсэгт хүчний жанжин штабд 3, Хил хамгаалах ерөнхий газарт 4, Улаанбаатар төмөр замын хувь нийлүүлэх компанид 9 нийт 16 орон тооны бус улсын байцаагчдын хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэж ажиллалаа.</p> <p>Тайлангийн хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг нийт 224 объектод хийж, хил хамгаалах байгууллагын нийт зөрчил дутагдлын 24.8 хувь нь эмнэлгийн тусламж үйлчилгээ, 6.8 хувь нь халдвар хамгааллын 40.7 хувь, хүнсний аюулгүй байдлын, 34.3 хувь нь орчны эрүүл ахуйн хяналтын чиглэлээр илэрсэн.</p>		
--	-------------	--	--	--	--

hrt




				<p>Илэрсэн зөрчлийг арилгуулахад улсын байцаагчийн 272 заалт бүхий 43 байгууллагад албан шаардлага өгсөнөөс 225 заалт нь биелэж албан шаардлагын хэрэгжилт 82.7 хувийн биелэлттэй.</p> <p>Улсын байцаагчийн зөвлөмж -11, улсын байцаагчийн дүгнэлт 276 бичиж хүргүүлсэн байна.</p> <p>Шалгалтад хамрагдсан 244 байгууллагад сургалт хийсэн.</p>		
	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	71%	72%	Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 348 буюу 93%-д эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн багц хуулийн хэрэгжилт 79 хувьтай байна.	2024.02.01-2024.09.25	
	Дэд арга хэмжээ 2.1.1: Төлөвлөгөөт хяналт шалгалтын хамтарсан удирдамж боловсруулж батлуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	20%	<p>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 420 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөөнд их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн эмнэлгүүдийн үйл ажиллагаанд Эрүүл мэндийн сайдын А/484 дүгээр тушаалаар баталсан хяналт шалгалтад хамрагдах 375 объектийн жагсаалтыг холбогдох яамдын хяналт шалгалттай уялдуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар, Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын хамтарсан удирдамжийг 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр 10-00/11, 03-01/01 дугаартай удирдамжийг батлуулж, БСШУЯ, ЭЭХЗГ, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газруудад албан бичгээр хүргүүлсэн.</p>	2024.01.01-2024.01.31
4.	Дэд арга хэмжээ 2.1.2: Улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагад хийсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэн, танилцуулга бичиж, удирдлагад танилцуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь		93.0 %	<p>Шалгалтад эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр хяналтын хуудсаар 348 эмнэлэг буюу 93 хувь хамруулсан. Үүнээс (ортой эмнэлэг 72, оргүй тусгай мэргэжлийн төв-5, Сумын эрүүл мэндийн төв-98, Тосгоны эрүүл мэндийн төв-4, Өрхийн эрүүл мэндийн төв-2, сувилахуйн төв-2, сэргээн засах-4, УАУ нэгдсэн эмнэлэг-7, клиник-135, нийслэлийн</p>	2024.09.25-2024.10.10

215




					<p>түргэн тусламжийн төв-1, сувилал 3) байна. Хяналт шалгалтын явцад нийт 2528 зөрчил илрүүлж, 37.9 хувийг газар дээр нь арилгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор улсын байцаагчийн хамтарсан 1927 заалттай 230 албан шаардлага, нийт 12 байгууллага, аж ахуйн нэгж, 1 иргэнд 13 сая 100 мянган (арван гурван сая нэг зуун) төгрөгийн шийтгэвэр ногдуулж, барагдуулсан. Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр гүйцэтгэлийн хяналтыг 68 эмнэлэгт газар дээр нь очиж, 119 эмнэлгийн ирүүлсэн материалд хяналт хийж, албан шаардлагаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг үнэлэхэд дунджаар 80 %-тай байна. 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хурлаар дүнг хэлэлцүүлж, шалгалтын мөрөөр зөрчил дутагдлыг арилгуулах ажлын хэсэг байгуулах шийдвэр гаргуулсан.</p>		
<p>Дэд арга хэмжээ 2.1.3: УНТЭ, УГТЭ, СЭМҮТ, Өргөө, Амгалан төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, /Өөжин, Юнимед интернейшинл, Реженатив медикал центр, Си эл даблью эйч ХХК-ний эмнэлгүүд/-д төлөвлөгөөт хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.</p>	Объектын хамралтын хувь		100%	<p>2024 оны 02 дугаар сарын 06-наас 2024 оны 10 дугаар сарын 05-ны хооронд УНТЭ, УГТЭ, СЭМҮТ, Өргөө, Амгалан амаржих газрууд, Өөжин мед, Юнимед интернейшинл, Реженатив медикал центр, Си эл даблью эйч ХХК-ний эмнэлгүүд, нийт 9 эмнэлэг төлөвлөснөөс 100 % хамруулсан.</p>	2024.02.20-2024.06.30	80%	
	Эрсдэлийн түвшин	Их-33.3%, дунд-55.5%	Эрсдэлийн түвшин буурна.	<p>Хяналтын хуудсаар үнэлэхэд эрсдэлийн түвшин 2 (22%) их, 4 (44 %) дунд, 3(34%) бага эрсдэлтэй үнэлэгдсэн. (УНТЭ-38, дунд, УГТЭ-25.3 хувь бага, СЭМҮТ-31% дунд, Өөжинмед эмнэлэг-56%, Реженатив медикал центр эмнэлэг-57% их, Си эл даблью эйч эмнэлэг-39% дунд, Өргөө амаржих газар-43.7% дунд, Амгалан амаржих-17.8 бага, Юнимед интернейшинл-26% бага), Илэрсэн зөрчлийг үндэслэн улсын байцаагчийн хамтарсан хугацаатай 82 заалттай албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлагын хэрэгжилт 73.3% -тай</p>	2024.02.01-2024.06.30		

9/8



					байна.		
		Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	71%	Хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирна.	Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 9 эмнэлэгт хууль сахин мөрдөлт 70.6 хувьтай байна. (УНТЭ-68%, УГТЭ-74%, СЭМҮТ-72%, Өргөө амаржих-56%, Амгалан амаржих-78%, Өөжинмед эмнэлэг-65%, Реженатив медикал центр эмнэлэг-65%, Си эл даблью эйч эмнэлэг-68%, Юнимед интернейшинл-76 %)	2024.02.01-2024.06.30	
5.	Арга хэмжээ 2.2. ТХШТХ-ийн 5.3. Эмнэлзүйн лабораторийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулна.	Объектын хамралтын хувь	100%	100%	Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад эмчилгээний чанарын хяналтаар нийт 80 бие даасан эмнэлзүйн лабортори хамрагдахаас 100% хамруулсан. Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Өвөрхангай, Ховд, Завхан, Булган аймгуудад эмнэлзүйн бие даасан лабораториуд байхгүй байгаа тул хяналт шалгалт хийгдээгүй болно.	2024.02.01-2024.06.05	100%
		Албан шаардлагын хэрэгжилтийн хувь	-	60%	Шалгалтын явцад хяналт шалгалтад хамрагдсан 40 лабораторид 307 заалт бүхий хугацаатай албан шаардлага хүргүүлж, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр албан шаардлагаар өгсөн үүрэг даалгаврыг 10 лабораторит газар дээр нь очиж, 20 лабораторийн ирүүлсэн материалд хяналт хийж, хэрэгжилтийг үнэлэхэд дунджаар 84.7 -ийн хэрэгжилтэй байна.	2024.01.01-2024.09.01	
		Арга хэмжээ 2.2.1: Урьдчилан сэргийлэх шалгалт хийх хамтарсан удирдамж боловсруулж, батлуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	Урьдчилан сэргийлэх шалгалт хийх удирдамж батлагдсан байна.	Эмнэлзүйн лабораторийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийг 10 асуудлын хүрээнд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бие даасан лабораторийг 100 хувь, нийслэлд нэр заасан 64 лабораториудыг хавсралтаар 2024 оны 02 дугаар сарын 15-наас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хүртэл хийж, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн танилцуулга, 4 хавсралт хүснэгтийн хамт 2024 оны 06 дугаар сарын 10-нд ирүүлэхээр Салбарын хяналтын газрын даргаар 2024	2024.02.01-2024.02.29




			20%	оны 02 дугаар сарын 05 өдөр багтсан 10-00/12 удирдамжийг батлуулсан.		
Арга хэмжээ 2.2.2: Урьдчилан сэргийлэх шалгалт хийнэ.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь		40%	Хяналт шалгалтад 80 эмнэлзүйн лаборатори хамрагдахаас 100 хувь хамруулсан . Шалгалтын явцад нийт 417 зөрчил илрүүлж, 184 зөрчлийг газар дээр нь арилгуулсан байна. Илэрсэн зөрчлийг үндэслэн 6 ААН-д 15000000 (арван таван сая) төгрөгийн шийтгэл оногдуулан, зөрчил үйлдэж олсон 799000 (долоон зуун ерэн есөн мянган) төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн, тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн хүчингүй болгох 14, түдгэлзүүлэх 11 лабораторийн саналыг харъяа Эрүүл мэндийн газруудад хүргүүлж шийдвэрлүүлсэн. ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар дүнг хэлэлцүүлж, шалгалтын мөрөөр зөрчил дутагдлыг арилгуулах Ажлын хэсэг байгуулах шийдвэр гаргуулсан.	2024.02.01-2024.06.05	
Арга хэмжээ 2.2.3: Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг нэгтгэж, танилцуулга бичиж, удирдлагад танилцуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь		40%	Эмнэлзүйн лабораторийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийг 10 асуудлын хүрээнд 2024 оны 02 дугаар сарын 15-наас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хүртэл хийж, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн танилцуулга, 4 хавсралт хүснэгтийн хамт нэгтгэж, 2024 оны 07 дугаар сарын 04-ны дотор яамны удирдлагад танилцуулж, 2024 оны 11 дүгээр сарын 21-нд удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох газруудад шийдвэрлэх асуудлыг хүргүүлж ажиллана.	2024.04.01-2024.06.20	


28



6.	<p>Арга хэмжээ 2.3. Эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ хийж буй эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэгт хяналт зохион байгуулна.</p>	Объектын хамралтын хувь		<p>100%</p> <p>Салбарын хяналтын газрын даргын баталсан дэмжлэгт хяналтад 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр 14 аймгийн 100, нийслэлийн 80, нийт 180 эрүүл мэндийн байгууллага (97 ӨЭМТ, 52 СЭМТ, 6 дүүргийн ЭМТ, 2 дүүргийн нэгдсэн эмнэлэг, 12 аймгийн нэгдсэн эмнэлэг, 4 Бүсийн оношилгоо эмчилгээний төв, 7 хувийн хэвшлийн ортой эмнэлэг) хамрагдаж, хамралт 100 хувьтай байна.</p> <p>Хяналт шалгалтаар дараах нөхцөл байдал тогтоогдсон. Үүнд: а/ӨЭМТ, СЭМТ-д цахим ашиглалтын бүртгэлээр шинээр ашиглагдаж байгаа VHS программ бүртгэлд 10175 хүүхдийн үзлэгийн мэдээлэл бүртгэгдээгүй, б/Ашиглаж байгаа программууд цахим хөгжүүлэлт хийгдээгүй, ашиглалт хангалтгүй, в/. Хүүхдийн эрт илрүүлгийг сургуулиар явж үзлэг хийхэд хүүхэдтэй ганцаарчилсан ярилцлага хийх үзлэгийн өрөөгүй, 18-с дээш насны үзлэгийн хариу олголт удаашралтай, 18-с дээш насны иргэд үзлэг шинжилгээнд хамралт муутай, ирдэггүй, ЭМД төлөлт дутуу зэргээс хамралт муу,</p> <p>Дэмжлэгт хяналтаар 406329 хүн эрт илрүүлэгт хамрагдаж, эрсдэлийн үнэлгээ хийлгэн, 128611 хүний өвчин эмгэгийн тохиолдлыг илрүүлж, 13648 тохиолдлыг хяналтанд авч, 8631 хүн онош тодруулахаар илгээж, 1171 хүний эрүүл мэндийн бүлэг сайжирсан үзүүлэлтэй байна.</p> <p>Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн бүртгэлээр 0-17 насны хүүхэд 61540 (38.9%), 18 наснаас дээш 344789 (89%) хүн хамрагдсан гэж нэгтгэгдэж байгаа боловч өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд цахим ашиглалтын бүртгэлээр шинээр ашиглагдаж</p>	2024.01.01-2024.06.30	100 %
----	--	-------------------------	--	---	-----------------------	-------




					<p>байгаа VHS программ бүртгэгч 10175 хүүхдийн үзлэгийн мэдээлэл бүртгэгдээгүй байна.</p> <p>Эрт илрүүлгийн багийг Улаанбаатар хотод 105 удаа, орон нутагт 80 удаа ажлын байрны сургалтанд хамруулсан буюу 195 эмнэлгийн эмч мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан.</p> <p>Нэгдсэн эмнэлгүүдийн дэмжлэгт төвд компьютер томограф, суурин рентген аппарат, маммограф, дуран, ЭХО, зүрхний ЭХО, ЭКГ, тархины цахилгаан бичлэг, тархины доплер зэрэг тоног төхөөрөмж, шаардлагатай лабораторийн урвалж бодис, оношлуур эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж хангагдсан байна.</p>		
7.	<p>Арга хэмжээ 2.4. Иргэн, ААН, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийнэ</p>	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хувь	100%	Ирсэн өргөдөл гомдлыг 100% бүрэн шийдвэрлэсэн байна.	<p>2024 оны тайлант хугацаанд хариуцсан хяналтын чиглэлээр 24 өргөдөл, гомдол 87 албан бичиг ирж, 56 албан бичигт хариу хүргүүлсэн.</p> <p>Байгууллага, иргэнээс ирүүлсэн нийт 24 өргөдөл гомдлыг хүлээн аваад 3 иргэний ирүүлсэн гомдлыг Эрүүгийн хуулийн 15.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалтад заасан гэмт хэргийн шинжтэй тул гомдлыг Цагдаагийн байгууллагад, 2 иргэний гомдлыг НЭМГ-т харьяаллын дагуу шилжүүлсэн. 1 гомдол давхардаж ирсэн.</p> <p>-4 эмнэлгийн эмч нартай холбоотой гомдолд зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 1 зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгож, 3 эмнэлгийн эмч нарт илэрсэн зөрчлийг үндэслэн 3 000 000 мянган (гурван сая) төгрөгийн шийтгэвэр, нөхөн төлбөр 9 000 000 (есөн сая), хууль бус орлого болох 4 800 000 (дөрвөн сая найман зуун мянга), нийт 16 800 000 мянган (арван зургаан сая найман зуун мянган) төгрөгийн торгууль ногдуулж барагдуулж ажилласан.</p> <p>- 1 эмнэлгийн дотоод үйл ажиллагаа тогтмолжоогүй тул хялбаршуулах замаар</p>	2024.01.01-2024.12.29	100%



				<p>торгуулийн арга хэмжээ авсан.</p> <p>-ЭХЭМҮТ, Монгол-Япон, УНТЭ, ХСҮТөвд 4 эмчид хариуцлага тооцуулах саналыг хүргүүлж, эргэн хариуцлага тооцсон тухай албан бичиг ирүүлсэн.</p> <p>-Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх албаны хүсэлтийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 14-наас-25-ны өдрүүдэд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авсан эмнэлгүүдэд нэхэмжлэлийн хяналт хийх шинжээч нарын бүрэлдхүүнд орж ажиллалаа.</p> <p>2021-2023 онуудад эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжлэл авсан (155) өвчний түүхэнд нэхэмжлэлийн хяналтыг хийж, илэрсэн зөрчил дутагдал, олдохгүй байгаа өвчний түүхийн жагсаалтыг гаргаж, ажлын хэсгийн ахлахад хүргүүлсэн</p>	
	<p>Дэд арга хэмжээ 2.4.1: Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамж боловсруулж батлуулж, хяналт шалгалт хийнэ.</p>	<p>Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь</p>	70%	<p>Эмнэлэг, эмчийн үйл ажиллагаатай холбоотой 19 гомдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийг боловсруулан, батлуулж хяналт шалгалт хийсэн тухай танилцуулга бичигдэж, удирдлагад танилцуулж иргэнд хариу хүргүүлэн ажилласан.</p>	2024.01.01-2024.12.29
	<p>Дэд арга хэмжээ 2.4.2: Төлөвлөгөөт бус хяналт шалгалт тус бүрт танилцуулга бичиж удирдлагад танилцуулна.</p>	<p>Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь</p>	30%	<p>Эмнэлэг, эмчийн үйл ажиллагаатай холбоотой 19 гомдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 5 иргэний гомдлыг мэдээллийн нэгдсэн бүртгэлд оруулж, зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хийгдэж, удирдлагад танилцуулж, иргэн байгууллагаас ирүүлсэн 19 гомдолд дурдсан асуудал үндэслэлтэй нь тогтоогдсон.</p> <p>Иргэний ирүүлсэн 3 өргөдөл гомдол үндэслэлгүй, 1 иргэн гомдолгүй гэж буцаан татсан.</p>	2024.01.01-2024.12.29


100



ЗОРИЛТ.3."УЛСЫН БАЙЦААГЧДЫН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛНА"

8.	<p>Арга хэмжээ 3.1. Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч нарт "Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж" чиглэлээр сургалт зохион байгуулна</p>	Сургалтын тайлан	25	<p>Сургалт зохион байгуулсан байна.</p> <p>100%</p>	<p>Салбарын хяналтын газрын даргын баталсан хөтөлбөрийн дагуу аймаг, нийслэлийн эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч нарт "Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж" чиглэлээр сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр цахим сургалтыг зохион байгуулж, эмчилгээний чанарын хяналтын 22 улсын байцаагчдыг хамруулсан.</p> <p>Хөтөлбөрийн дагуу Манас таталтын урьдал үеийн оношилгоо, эмчилгээний зарчим, хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж, авах арга хэмжээ зэрэг сэдвийн хүрээнд хийгдэж, улсын байцаагч нарын мэдлэгийг нэмж, мэдээлэл өгсөн ач холбогдолтой сургалт болсон.</p>	2024.03.01-2024.04.30	100%
9.	<p>Арга хэмжээ 3.2. Аймаг, нийслэлийн ЭМГ-ын улсын байцаагчдын зөвлөгөөн зохион байгуулна.</p>	Зөвлөгөөний тайлан	128	<p>Зөвлөгөөн зохион байгуулсан байна.</p> <p>100%</p>	<p>ДЭМБ-ийн санхүүжилтээр Улсын байцаагчдын нэгдсэн зөвлөлгөөнийг хяналт шалгалтыг хэрэгжүүлж буй улсын байцаагчдад эрүүл мэндийн салбарын болон хяналтын эрх зүйн орчны өөрчлөлт, шинэчлэлт, тулгамдаж буй асуудлын шийдлийг тодорхойлоход улсын байцаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд зорилгоор Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр нэгдсэн зөвлөлгөөний удирдамж, хөтөлбөр, зардлын төсөв, сургалтад хамрагдах аймаг, нийслэлийн улсын байцаагчдын нэрсийг гаргаж батлуулж, 2024 оны 05 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд сургалтыг зохион байгуулсан.</p> <p>ЭМЯ-ны СХГ, аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч ЗХЖШ, ХХЕГ, УБТЗ болон ЭЭХХЗГ-ын нийт 130 улсын байцаагчийг хамруулсан.</p> <p>Хяналт шалгалтын эрх зүйн орчинг</p>	2024.02.01-2024.06.30	100%

Handwritten signature or mark.




				<p>боловсронгуй болгох”, “Улсын байцаагчдыг чадавхижуулах” үндсэн зорилтуудын хүрээнд илтгэлүүд тавигдахаас гадна хяналт шалгалтад ашиглах журам, зааврын шинэчилсэн төслийг хэлэлцүүлж, байцаагчдын саналыг авч ажилласан. Ийнхүү улсын байцаагчдын зөвлөгөөн зорилгоо биелүүлж, онолын мэдээлэл сонсохоос гадна шинэчлэн боловсруулсан журам, зааврын төслөө танилцуулан, санал авч сайжруулах, шинэ салбарт шилжин ирснээр тулгамдаж буй асуудлаа хэлэлцэж зөвлөмж гаргасан үр дүнтэй зөвлөгөөн болсон.</p> <p>Зөвлөгөөний зардлын тооцоог Дэлхий эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн яамны санхүүгийн газарт 359 хуудас бүхий санхүүгийн тайланг хүргүүлсэн.</p>	
	Дүн				93.5%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин(биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Арга хэмжээ 1. ЭМЯ-ны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөл болон мэргэжлийн холбоодтой хамтран кредит цаг олгох сургалтанд хамрагдана.	Суралцсан кредит цаг		2 багц цаг	2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Эрүүл мэндийн яамны дэргэдэх эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга Э.Баярмаагийн баталсан “Эмнэлзүй эмгэг судлалын онош, түүний хэлбэржилт” танхимын сургалтын хөтөлбөрийн дагуу эмгэг судлалын тусламж үйлчилгээний түгээмэл үйлдэл 7015:2023 стандарт, эмнэлзүй эмгэг судлалын онош, түүний хэлбэржилт сэдэвт багц цагийн сургалтад	2024.01.01-2024.12.29	100%

202



					хамрагдаж 2 багц цаг, гэрчилгээ авч, мэдлэгээ нэмэгдүүлсэн.		
2.	Арга хэмжээ 2. “Хууль зүйн мэдээлэл болон хууль хэрэглэх арга зүй” сургалтанд хамрагдаж хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлнэ.	Гэрчилгээ сертификатыг	-	1-ээс доошгүй	“Эрх зүйн боловсрол ба эрүүл мэнд” ТББ-аас зохион байгуулсан “Эмнэлгийн эрх зүй ба ёс зүй” сэдэвт (2 кредит) сургалтанд 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр цахимаар сууж, батламж авч, эмнэлгийн хууль эрхзүйн мэдлэгээ дээшлүүлсэн.	2024.01.01-2024.12.29	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
(Албан тушаал)

Б. Байгальмаал
..... / Б.Байгальмаал /
(Нэр, гарын үсэг)

2024.12.05
.....
(Огноо)

2024.12.05

024

